

БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

(2025 оны I улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн

Банкуудаас 2025 оны 4 дүгээр сарын 14-22-ны өдрийн хооронд санал асуулга хэлбэрээр өнгөрсөн болон ирэх 3 сарын хугацааны зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг цуглуулан нэгтгэж, тайлан боловсруулав. Үр дүнг товч танилцуулбал:

Зээлийн шалгуур

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том банкууд ААН-ийн зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй бол иргэдийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулжээ. Харин дунд болон жижиг банкууд зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна.
- Ирэх 3 сарын хугацаанд банкууд зээлийн шалгуураа хэвээр нь хадгалах хандлагатай байна.

Зээлийн нөхцөл

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд банкууд ААН, иргэдийн зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулаагүй байна.
- Ирэх 3 сарын хугацаанд банкууд зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах хүлээлттэй байна.

Зээлийн эрэлт

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том банкуудын ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн бол иргэдийн зээлийн эрэлт төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Дунд болон жижиг банкуудын зээлийн эрэлтэд өөрчлөлт ороогүй байна.
- Ирэх 3 сард том банкуудын ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэж, иргэдийн зээлийн эрэлт өөрчлөгдөхгүй хэвэндээ байна гэсэн хүлээлттэй байна. Дунд болон жижиг банкуудын хувьд зээлийн эрэлт өөрчлөгдөхгүй гэж үзжээ.

Зээлийн нийлүүлэлт

- Ирэх 3 сард том банкууд ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Харин дунд болон жижиг банкууд зээлийн нийлүүлэлтээ хэвээр хадгалах хандлагатай байна.

Хүснэгт 1.1 Судалгааны нэгдсэн үр дүн

Банкууд / Зээлийн төлөв	Зээлийн шалгуур		Зээлийн нөхцөл		Зээлийн эрэлт		Зээлийн нийлүүлэлт	
	ААН	Иргэд	ААН	Иргэд	ААН	Иргэд	ААН	Иргэд
Өнгөрсөн 3 сарын хугацаанд								
Том	0	↑	0	0	↑	0		
Дунд	0	0	0	0	0	0		
Жижиг	0	0	0	0	0	0		
Ирэх 3 сарын хугацаанд								
Том	0	0	0	0	↑	0	↑	0
Дунд	0	0	0	0	0	0	0	0
Жижиг	0	0	0	0	0	0	0	0

Тэмдэглэл: ↑ бага зэрэг чангарах/нэмэгдэх; ↑↑ нэлээд чангарах/нэмэгдэх; 0 өөрчлөгдөөгүй; ↓ бага зэрэг сулрах/буурах; ↓↓ нэлээд сулрах/буурах

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь банкуудаас олгож буй зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт болон нийлүүлэлт, тэдгээрийн цаашдын төлөвийг тодорхойлоход оршино.

Судалгааны хамрах хүрээ

Банкны зээлийн төлөвийн судалгаанд нийт 12 банкиг хамруулсан бөгөөд тухайн банкны зээлийн үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтнуудаас асуулга авсан болно.

Арга зүйн товч тайлбар

Банкны зээлийн төлөвийн судалгааг санал асуулга хэлбэрээр зохион байгуулдаг бөгөөд (i) зээлийн шалгуур, (ii) зээлийн нөхцөл, (iii) зээлийн эрэлт болон (iv) зээлийн нийлүүлэлт гэсэн 4 үндсэн хэсгээс бүрдэнэ. Судалгааны үр дүнг нэгтгэхдээ банкуудын чанарын хариултуудыг нэг утгатайгаар тодорхойлохын тулд тоон утга руу хөрвүүлсэн. Ингэхдээ $[-1;+1]$ хоорондох утгуудад чанарын асуултуудыг Хүснэгт 1.2-т өгөгдсөн байдлаар индексэд хөрвүүлдэг.

Хүснэгт 1.2 Индексийн тооцоолол					
Индексийн утга	-1.0	-0.5	0	0.5	1.0
Зээлийн шалгуур	Нэлээд суларсан/суларна	Бага зэрэг суларсан/суларна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан/чангарна	Нэлээд чангарсан/чангарна
Зээлийн нөхцөл	Нэлээд суларсан/суларна	Бага зэрэг суларсан/суларна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан/чангарна	Нэлээд чангарсан/чангарна
Зээлийн эрэлт	Нэлээд багассан/багасна	Бага зэрэг багассан/багасна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдсэн/нэмэгдэнэ	Нэлээд нэмэгдсэн/нэмэгдэнэ
Зээлийн нийлүүлэлт	Нэлээд бууруулна	Бага зэрэг бууруулна	Өөрчлөхгүй	Бага зэрэг нэмэгдүүлнэ	Нэлээд нэмэгдүүлнэ


Нийт банкны системийн зээлийн төлөвийг тодорхойлохдоо банк тус бүрийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээг тухайн банкны харгалзах индексээр үржүүлэх замаар жигнэсэн дундаж утгыг тооцсон болно. Тухайн хугацаан дахь ерөнхий индексийн утга нь зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх өнгөрсөн 3 сарын байдал болон ирэх 3 сарын төлөвийг илэрхийлнэ.

I. Зээлийн шалгуур

1.1 Аж ахуйн нэгжийн зээлийн шалгуур

- Банкуудын ААН-ийн зээлийн шалгуур 2018 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2022 онд зээлийн шалгуур нэлээд чангарсан байна. Харин 2023 оны I улирлаас сулруулж эхэлжээ. 2025 оны I улиралд ААН-ийн зээлийн шалгуурын индекс 0 гарсан бөгөөд банкууд зээлийн шалгуураа хэвээр нь хадгалсан байна. Ирэх улиралд банкууд ААН-ийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулах төлөвтэй байна (Зураг 1).

Зураг 1. ААН-ийн зээлийн шалгуур ба хүлээлт




- Банкууд 2025 оны I улиралд ХАА-н салбарт олгох зээлийн шалгуурыг бага зэрэг сулруулж, боловсруулах үйлдвэрийн салбарт өөрчлөлт оруулаагүй бол бусад салбарын зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулсан байна. 2025 оны II улиралд худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн шалгуурыг хэвээр нь хадгалах, уул уурхайн салбарын зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулах, бусад салбарт олгох зээлийн шалгуурыг бага зэрэг сулруулах төлөвтэй байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ААН-ийн зээлийн шалгуур, салбараар						
Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2025.I улирлын хүлээлт	-0.16	-0.21	-0.07	-0.17	-0.18	-0.18
2025.I улирлын үр дүн	0	-0.20	0.17	0	0.10	0.09
2025.II улирлын хүлээлт	-0.05	-0.21	0.30	-0.12	-0.10	0

- Банкууд 2025 оны I улиралд аж ахуйн нэгжийн зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна (Зураг 2).


Зураг 2. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс



1.2 Иргэдийн зээлийн шалгуур

- Банкуудын иргэдийн зээлийн шалгуур 2020-2021 онд харьцангуй тогтвортой байсан бол 2022 онд зээлийн шалгуур нэлээд чангарсан байна. Харин 2023 оны I улирлаас сулруулж эхэлсэн бол мөн оны сүүлээр эргээд бага зэрэг чангаруулжээ. 2025 оны I улиралд иргэдийн зээлийн шалгуурын индекс 0.33 гарсан бөгөөд банкууд зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулжээ. Харин ирэх улиралд банкууд иргэдийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулах төлөвтэй байна (Зураг 3).

Зураг 3. Иргэдийн зээлийн шалгуур ба хүлээлт




- Банкууд 2025 оны I улиралд бизнесийн болон малчны зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан бол тэтгэвэр, цалингийн зээлийн шалгуураа нэлээд, хэрэглээ, автомашины зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулсан байна. Ирэх улиралд цалингийн зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулах, бусад төрлийн зээлийн шалгуураа хэвээр хадгалах төлөвтэй байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Иргэдийн зээлийн шалгуур, зээлийн ангиллаар

Хугацаа	Нийт зээл	Цалин-гийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2025.I улирлын хүлээлт	-0.11	0	0.10	0.28	0	0	-0.14
2025.I улирлын үр дүн	0.33	0.53	0.82	0.39	-0.27	-0.22	0.07
2025.II улирлын хүлээлт	-0.07	0.25	0	0	0	0	0

- 2025 оны I улиралд бусад банкууд болон санхүүгийн байгууллагуудын өрсөлдөөн буурч, эрсдэл нэмэгдсэн нь иргэдийн зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулахад голлон нөлөөлжээ (Зураг 4).

Зураг 4. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс




II. Зээлийн нөхцөл

2.1 Аж ахуйн нэгжийн зээлийн нөхцөл

- Банкуудын ААН-ийн зээлийн нөхцөл 2018 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2021 онд огцом суларч, 2022 онд бага зэрэг чангарсан. Харин 2023 оноос хойш харьцангуй тогтвортой байна. 2025 оны I улиралд банкууд ААН-ийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан бөгөөд ирэх улиралд бага зэрэг чангаруулах төлөвтэй байна (Зураг 5).

Зураг 5. ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл, хүлээлт




- Банкууд 2025 оны I улиралд ХАА, худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан бол уул уурхай, боловсруулах үйлдвэр, барилгын салбарт олгох зээлийн нөхцөлөө өөрчлөөгүй байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2024.IV улирлын үр дүн	0	0	0	0	0	0
2025.I улирлын үр дүн	-0.04	-0.04	0	0	0	-0.04

- 2025 оны I улиралд банкууд ААН-ийн зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, хугацааг уртасгах болон барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах зэргээр зээлийн нөхцөлөө сулруулжээ (Зураг 6).

Зураг 6. ААН-ийн зээлийн нөхцөлүүд



- Хүснэгт 4-т банкуудаас ААН-д тухайн улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХүү), жигнэсэн дундаж хугацаа (ЖДХугацаа) болон шинээр олгосон зээлийн хэмжээг түүвэр судалгааны үр дүнд гарсан зээлийн хүү, хугацаа, хэмжээний индекстэй харьцуулан эдийн засгийн салбаруудаар харуулав. 2025 оны I улиралд боловсруулах үйлдвэрийн салбараас бусад салбарт олгосон зээлийн ЖДХүү өмнөх улирлаас 0.1-4.1 нэгж хувиар өссөн бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй гарсан байна. Харин боловсруулах үйлдвэрийн салбарын хувьд эсрэг үр дүн гарчээ. Худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн ЖДХугацаа 5.1 сараар уртассан бөгөөд энэ нь түүвэр судалгааны зээлийн хугацааны нөхцөлийг сулруулсан үр дүнтэй нийцтэй гарсан байна. Харин бусад салбаруудад олгосон зээлийн ЖДХугацаа богиноссон бол банкууд нийт салбаруудад олгосон зээлийн хугацаанд өөрчлөлт оруулаагүй эсвэл хугацаа уртассан гэж хариулсан байна. 2025 оны I улиралд боловсруулах үйлдвэрийн салбарт шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэн нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй гарсан байна. Харин бусад салбарт шинээр олгосон зээлийн хэмжээ буурсан нь түүвэр судалгааны зээлийн хэмжээний индекстэй харьцуулахад эсрэг үр дүн гарчээ.


Хүснэгт 4. ААН-д олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацаа, салбараар						
Зээлийн нөхцөлүүд	Хугацаа	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
Банкуудын зээлийн ЖДХүү (%)	- 2024.IV улирал	7.8	13.3	16.7	16.7	16.3
	- 2025.I улирал	11.9	16.0	14.1	17.7	16.4
	- Өөрчлөлт (%)	<u>+4.1</u>	<u>+2.7</u>	<u>-2.6</u>	<u>+1.0</u>	<u>+0.1</u>
Зээлийн хүүний нөхцөл (судалгааны үр дүн)	2025.I улирал	0.23	0.15	0.23	0.25	0.28
Банкуудын зээлийн ЖДХугацаа (сар)	- 2024.IV улирал	56.0	18.1	39.8	29.5	35.0
	- 2025.I улирал	44.3	16.4	24.0	29.3	40.1
	- Өөрчлөлт (сар)	<u>-11.7</u>	<u>-1.7</u>	<u>-15.8</u>	<u>-0.2</u>	<u>+5.1</u>
Зээлийн хугацааны нөхцөл* (судалгааны үр дүн)	2025.I улирал	-0.21	0.00	-0.18	0.00	-0.16
Банкуудын шинээр олгосон зээлийн хэмжээ (тэрбум төг.)	- 2024.IV улирал	218.3	1,370.9	565.5	722.5	6,472.7
	- 2025.I улирал	105.7	741.9	669.2	531.5	6,276.5
	- Өөрчлөлт (%)	<u>-51.6</u>	<u>-45.9</u>	<u>+18.3</u>	<u>-26.4</u>	<u>-3.0</u>
Зээлийн хэмжээний нөхцөл* (судалгааны үр дүн)	2025.I улирал	-0.21	0.00	-0.18	0.00	-0.17

*-Зээлийн хугацаа, хэмжээний нөхцөл (-) утгатай бол нөхцөлийг сулруулсан буюу зээлийн хугацаа уртасч, зээлийн хэмжээ нэмэгдсэнийг илэрхийлнэ. (+) утгатай бол нөхцөлийг чангаруулсан буюу зээлийн хугацаа богиносч, зээлийн хэмжээ буурсныг илэрхийлнэ.

2.2 Иргэдийн зээлийн нөхцөл

- Банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө 2021 онд сулруулж, 2022 онд чангаруулж байсан бол 2023 оны эхэнд бага зэрэг сулруулжээ. 2024 оны эхний 2 улиралд банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан бол сүүлийн 3 улиралд өөрчлөөгүй байна. Ирэх улиралд банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах төлөвтэй байна (Зураг 7).

Зураг 7. Иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл, хүлээлт




- Банкууд 2025 оны I улиралд малчны болон хэрэглээний зээлийн нөхцөлийг бага зэрэг чангаруулж, бусад төрлийн зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулаагүй байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл, зээлийн төрлөөр

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
2024.IV улирлын үр дүн	0	0	0	0	0	0	0
2025.I улирлын үр дүн	0	0	0	0.09	0	0.10	0

- 2025 оны I улиралд банкуудын зээлийн хүү нэмэгдэж чангаруулах чиглэлд, хэмжээ, хугацаа нэмэгдсэнээр сулруулах чиглэлд нөлөөлсөн бөгөөд иргэдийн зээлийн ерөнхий нөхцөлд өөрчлөлт ороогүй байна (Зураг 8).

Зураг 8. Иргэдийн зээлийн нөхцөлүүд



- Хүснэгт 6-д банкуудаас иргэдэд тухайн улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХүү), жигнэсэн дундаж хугацаа (ЖДХугацаа) болон шинээр олгосон зээлийн хэмжээг түүвэр судалгааны үр дүнд гарсан зээлийн хүү, хугацаа, хэмжээний индекстэй харьцуулан зээлийн төрлөөр харуулав. 2025 оны I улиралд хэрэглээ, тэтгэвэр, автомашин, цалингийн зээлийн ЖДХүү өмнөх улирлаас бага зэрэг нэмэгдсэн бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй байна. Харин малчны зээлийн ЖДХүү 0.2%-аар буурсан бол түүвэр судалгаагаар эсрэг үр дүн гарсан байна. Малчин, цалингийн зээлийн ЖДХугацаа 0.1-0.8 сараар нэмэгдэж, бусад төрлийн зээлийн ЖДХугацаа 0.4-4.7 сараар богиноссон нь түүвэр судалгааны үр дүнгээс эсрэг гарсан байна. 2025 оны I улиралд иргэдэд шинээр олгосон хэрэглээний зээлийн хэмжээ буурч, цалингийн зээлийн хэмжээ нэмэгдсэн нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй гарчээ. Харин бусад төрлийн зээлийн хувьд түүвэр судалгааны зээлийн хэмжээний индекстэй харьцуулахад эсрэг үр дүн гарчээ.

Хүснэгт 6. Иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацаа, салбараар						
Зээлийн нөхцөлүүд	Хугацаа	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Малчны зээл	Автомашинны зээл
Банкуудын зээлийн ЖДХүү (%)	- 2024.IV улирал	17.4	15.9	22.5	21.2	17.9
	- 2025.I улирал	17.5	17.0	23.9	21.0	18.8
	- Өөрчлөлт (%)	<u>+0.1</u>	<u>+1.1</u>	<u>+1.4</u>	<u>-0.2</u>	<u>+0.9</u>
Зээлийн хүүний нөхцөл (судалгааны үр дүн)	2025.I улирал	0.31	0.36	0.21	0.50	0.17
Банкуудын зээлийн ЖДХугацаа (сар)	- 2024.IV улирал	28.5	13.7	31.2	24.1	20.6
	- 2025.I улирал	28.6	15.2	30.8	24.9	15.9
	- Өөрчлөлт (сар)	<u>+0.1</u>	<u>-1.5</u>	<u>-0.4</u>	<u>+0.8</u>	<u>-4.7</u>
Зээлийн хугацааны нөхцөл* (судалгааны үр дүн)	2025.I улирал	0.00	-0.22	0.00	0.00	-0.23
Банкуудын шинээр олгосон зээлийн хэмжээ (тэрбум төг.)	- 2024.IV улирал	1,708.8	654.8	165.0	87.0	21.3
	- 2025.I улирал	1,756.2	1,132.9	152.3	173.2	22.7
	- Өөрчлөлт (%)	<u>+2.8</u>	<u>+73.0</u>	<u>-7.7</u>	<u>+99.0</u>	<u>+6.6</u>
Зээлийн хэмжээний нөхцөл* (судалгааны үр дүн)	2025.I улирал	-0.05	0.02	0.24	0.00	0.03


*-Зээлийн хугацаа, хэмжээний нөхцөл (-) утгатай бол нөхцөлийг сулруулсан буюу зээлийн хугацаа уртасч, зээлийн хэмжээ нэмэгдсэнийг илэрхийлнэ. (+) утгатай бол нөхцөлийг чангаруулсан буюу зээлийн хугацаа богиносч, зээлийн хэмжээ буурсныг илэрхийлнэ.

III. Зээлийн эрэлт

3.1 Аж ахуйн нэгжийн зээлийн эрэлт

- ААН-ийн зээлийн эрэлт 2020 оны I, II улирлыг эс тооцвол 2018 оноос өнөөг хүртэл өндөр хэвээр байна. 2025 оны I улиралд ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарчээ. Ирэх улиралд ААН-ийн зээлийн эрэлт мөн өндөр хэвээр байх бөгөөд өмнөх улирлын хүлээлтийн утгаас бага зэрэг өсөх төлөвтэй байна (Зураг 9).

Зураг 9. ААН-ийн зээлийн эрэлт ба хүлээлт




- 2025 оны I улиралд ХАА-с бусад бүх салбаруудын зээлийн эрэлт нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Ялангуяа, боловсруулах үйлдвэрийн салбарын зээлийн эрэлт бусад салбаруудтай харьцуулахад өндөр байжээ. 2025 оны II улиралд нийт салбаруудын зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэх төлөвтэй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. ААН-ийн зээлийн эрэлт, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2025.I улирлын хүлээлт	0.23	0.20	0.13	0.20	0.24	0.23
2025.I улирлын үр дүн	0.29	-0.01	0.20	0.40	0.23	0.27
2025.II улирлын хүлээлт	0.33	0.45	0.23	0.26	0.13	0.29

- 2025 оны I улиралд эргэлтийн болон үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын зээлийн хүсэлт нэмэгдсэн нь ААН-ийн зээлийн эрэлт нэмэгдэхэд голлон нөлөөлжээ (Зураг 10).


Зураг 10. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс



3.2 Иргэдийн зээлийн эрэлт

- Иргэдийн зээлийн эрэлт 2018 оноос хойш нэлээд хэлбэлзэлтэй байсан бол 2021 оны III улирлаас өнөөг хүртэл өндөр хэвээр байна. 2025 оны I улиралд иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан боловч хүлээлтийн утгаас буурсан байна. Ирэх улиралд иргэдийн зээлийн эрэлт мөн бага зэрэг нэмэгдэх боловч өмнөх улирлын хүлээлтийн утгаас буурах төлөвтэй байна (Зураг 11).

Зураг 11. Иргэдийн зээлийн эрэлт ба хүлээлт




- 2025 оны I улиралд бүх төрлийн зээлийн эрэлт нэмэгдсэн бөгөөд энэ нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. 2025 оны II улиралд тэтгэврийн зээлээс бусад бүх төрлийн зээлийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа, малчны зээлийн эрэлт нэлээд нэмэгдэх төлөвтэй байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Иргэдийн зээлийн эрэлт, зээлийн төрлөөр

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
2025.I улирлын хүлээлт	0.39	0.36	0.50	0.49	0.38	0.77	0.46
2025.I улирлын үр дүн	0.08	0.07	0.24	0.43	0.35	0.22	0.19
2025.II улирлын хүлээлт	0.07	0.15	-0.06	0.16	0.44	0.50	0.19

- 2025 оны I улиралд эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэрэглэгчдийн итгэл нэмэгдэж, удаан эдэлгээт барааны худалдан авалт, бусад санхүүгийн хэрэгцээ иргэдийн зээлийн эрэлт нэмэгдэхэд голлох нөлөөг үзүүлжээ (Зураг 12).

Зураг 12. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс




IV. Зээлийн нийлүүлэлт

4.1 Аж ахуйн нэгжийн зээлийн нийлүүлэлт

- Банкууд ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ 2021 оноос өнөөг хүртэл нэмэгдүүлэх хандлагатай хэвээр байна. 2025 оны I улиралд ААН-д нийт 5.97 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх улирлаас 8.2%-аар буурсан бол өмнөх оны мөн үеэс 23.8%-аар өссөн үзүүлэлт байлаа. 2025 оны II улиралд банкууд ААН-д олгох зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна (Зураг 13).

Зураг 13. ААН-ийн зээлийн нийлүүлэлтийн төлөв ба шинээр олгосон зээл



- Банкууд 2025 оны II улиралд бүх салбарт олгох зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна. Ялангуяа, ХАА, худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн нийлүүлэлтээ бусад салбаруудаас илүүтэй нэмэгдүүлэх хандлагатай байна (Хүснэгт 9).


Хүснэгт 9. ААН-ийн зээлийн нийлүүлэлт, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2025.I улирлын хүлээлт	0.34	0	0.18	0.26	0.32	0.35
2025.II улирлын хүлээлт	0.36	0.47	0.18	0.26	0.31	0.44

4.2 Иргэдийн зээлийн нийлүүлэлт

- Банкууд иргэдийн зээлийн нийлүүлэлтээ 2022 оны III улирлыг эс тооцвол 2021 оноос өнөөг хүртэл нэмэгдүүлэх хандлагатай хэвээр байна. Банкууд 2025 оны I улиралд иргэдэд 7.06 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх улирлаас 8.4%-аар өссөн үзүүлэлт болж, өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Ирэх 2025 оны II улиралд банкууд иргэдэд олгох зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй байна (Зураг 14).

Зураг 14. Иргэдийн зээлийн нийлүүлэлтийн төлөв ба шинээр олгосон зээл



*- Ипотекийн зээлийг эс тооцов.

- Банкууд 2025 оны II улиралд тэтгэврийн зээлээс бусад бүх төрлийн зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна. Ялангуяа, автомашин, бизнес, хэрэглээний зээлийн нийлүүлэлтээ бусад төрлөөс илүүтэй нэмэгдүүлэх хандлагатай байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Иргэдийн зээлийн нийлүүлэлт, зээлийн төрлөөр							
Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашин зээл
2025.I улирлын хүлээлт	0.40	0.40	0.41	0.49	0.38	0.77	0.59
2025.II улирлын хүлээлт	0.09	0.15	-0.09	0.30	0.31	0.28	0.32

Хавсралт 1. ААН болон иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс

Хүснэгт 11. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар (2025.I улирал)						
Хүчин зүйлс	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
Эх үүсвэрийн зардал, боломж						
Эх үүсвэрийн өртөг	0.11	-0.19	0.15	0.05	0.07	0.10
Санхүүжилтийн боломж	-0.15	-0.21	0	-0.17	0	-0.31
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	0.08	0.02	0.15	0.05	0.07	0.08
Өрсөлдөөн						
Бусад банкуудын өрсөлдөөн	-0.14	0	0	-0.14	0	-0.14
Бусад санхүүгийн байгууллагын өрсөлдөөн	-0.03	0	0	0	0	-0.02
Санхүүгийн захын өрсөлдөөн	-0.03	0	0	0	0	-0.02
Эдийн засгийн байдал						
Эдийн засгийн өсөлт	-0.06	-0.19	0.15	0.05	0.07	-0.04
Инфляц	0.10	0.02	0.15	0.05	0.07	0.12
Валютын ханш	0.10	0.02	0.15	0.05	0.07	0.12
Эрсдэл						
Тухайн салбарын төлөв байдал	-0.07	-0.19	0.15	-0.12	0.07	-0.07
Барьцаа хөрөнгийн эрсдэл	-0.15	-0.21	0	-0.17	0	-0.15
Банкны эрсдэл даах чадвар	-0.02	0	0	0	0	-0.02

Хүснэгт 12. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр (2025.I улирал)							
Хүчин зүйлс	Нийт зээл	Цалин-гийн зээл	Тэтгэв-рийн зээл	Хэрэглээ-ний зээл	Бизнес-ийн зээл	Малчны зээл	Автомашин-ны зээл
Эх үүсвэрийн зардал, боломж							
Эх үүсвэрийн өртөг	0	0	0	0	0	0	-0.23
Санхүүжилтийн боломж	0.01	0	0	0	-0.01	0	-0.23
Өрсөлдөөн							
Бусад банкны өрсөлдөөн	0.13	0.03	0.07	0	-0.08	0	-0.24
Бусад санхүүгийн байгууллагын өрсөлдөөн	0.11	0	0	0	-0.01	0	-0.24
Эдийн засгийн байдал							
Эдийн засгийн өсөлт	0.11	0.13	0.08	0.16	0.01	0	0.03
Инфляц	0.11	0.13	0.07	0.15	0.07	0	0.03
Валютын ханш	0.01	0	0	0	0	0	0
Эрсдэл							
Төлбөрийн чадвар	0.18	0.21	0.24	0.29	0	0	0.03
Барьцаа хөрөнгийн эрсдэл	0.02	0.03	0	0	0	0	0
Банкны эрсдэл даах чадвар	0.02	0.03	0	0	0	0	-0.01

Хавсралт 2. ААН болон иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс

Хүснэгт 13. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар (2025.I улирал)						
Хүчин зүйлс	Нийт зээл	ХАА	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
Санхүүжилтийн хэрэгцээ						
Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт	0.40	0.21	0.21	0.38	0.28	0.28
Эргэлтийн хөрөнгө	0.44	0.45	0.21	0.41	0.41	0.43
Ажиллах хүчин болон тоног төхөөрөмж	0.30	0.21	0.21	0.25	0.28	0.29
Компанийн нэгдэл, бүтцийн өөрчлөлт	0	0	0	0	0	0
Зээлийн хүүний ерөнхий түвшин	-0.10	-0.01	-0.15	-0.04	-0.07	-0.11
Өрийн дахин санхүүжилт	0.02	0	0	0	0	0
Бусад санхүүжилтийн хэлбэрүүд						
Дотоод санхүүжилт	0.01	0	0	0	0.01	0.01
Бусад банкуудаас зээлэх	-0.09	0	0	0	0.01	-0.10
Бусад санхүүгийн байгууллагаас зээлэх	0.01	0	0	0	0.01	0.01
Үнэт цаас, хувьцаа гаргах	0	0	0	0	0	0
Гадаад зах зээлээс санхүүжилт татах	0	0	0	0	0	0

Хүснэгт 14. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр (2025.I улирал)							
Хүчин зүйлс	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
Санхүүжилтийн хэрэгцээ							
Удаан эдэлгээтэй бараа худалдан авалт	0.08	0.10	0.07	0.15	0.08	0	0.17
Хэрэглэгчдийн итгэл	0.11	0.15	0.07	0.15	0.08	0	0.07
Зээлийн хүүний ерөнхий түвшин	0.01	0	0	0.01	0	0	0.24
Өрийн дахин санхүүжилт	0.09	0.10	0.07	0.15	0	0	0
Үнэт цаас худалдан авалт	0.01	0.00	0	0	0	0	0
Бусад санхүүжилтийн хэлбэрүүд							
Өрхийн хуримтлал	0	0	0.05	0	0	0	0
Бусад банкуудаас зээлэх	0	0	0	0	0.01	0	0.02
Санхүүжилтийн бусад эх үүсвэр	0	0	0	0	0.01	0	0.02